



V/2022


Тархаасан: 2022 оны 6 дугаар сарын 14



## Нас гүйцсэн эр хонины үнэ Ховд аймагт хамгийн өндөр буюу 283.5 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2022 оны 5 дугаар сард атны үнэ 1.5 сая төгрөг болж, өмнөх сараас 33.1 мянган төгрөгөөр, соёолон үрээнийх 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 7.8 мянган төгрөг, хязаалан гуных 1.4 сая төгрөг болж, өмнөх сараас 37.8 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 237.1 мянган төгрөг болж, өмнөх сараас 9.2 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 161.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 600 төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), мянган төгрөгөөр




Эр хонины үнэ 2022 оны 5 дугаар сард Ховд аймагт хамгийн их буюу 283.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 27.6 мянган төгрөгөөр өссөн байна. Хэнтий аймагт хамгийн бага буюу 185.6 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.1 мянган төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 5 дугаар сард, мянган төгрөгөөр




Цагаан ноолуурын 1 кг-ын үнэ 2022 оны 5 дугаар сард Баянхонгор аймагт хамгийн их буюу 110.0 мянган төгрөг, Дорнод болон Сүхбаатар аймагт хамгийн бага буюу 50.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 3. ЦАГААН НОЛУУРЫН 1 КГ-ЫН ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 5 дугаар сард, төгрөгөөр



Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2022 оны 5 дугаар сард 5.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 300 төгрөгөөр өссөн байна. Харин ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 86.1 мянган төгрөг болж, өмнөх сараас 21.9 мянган төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 4. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 5 дугаар сард, төгрөгөөр



Хивэгний (25 кг) үнэ 2022 оны 5 дугаар сард Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 25.8 мянган төгрөг, Дархан-Уул аймагт хамгийн бага буюу 10.0 мянган төгрөг байна.

**Тооцох аргачлал:**

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



**Эх үүсвэр:**

ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

**Мэдээлэл авах холбоос**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2022 оны 7 дугаар сарын 19

Эдийн засгийн статистикийн газрын дарга  
А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
Гэрээт ажилтан Г.Ануужин  
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212